

2024 он 05 сар 04 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

**Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах  
болон хөнгөлөлттэй зээл авах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтуудыг тус тус үндэслэн “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

- “Говь” ХК нь дараах нөхцөлийн дагуу “Голомт Банк”-тай “Ноолуур бэлтгэлд зориулан олгох зээл”-ийн гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
  - Зээлийн хэмжээ: 9,500,000,000 /есөн тэрбум таван зуун сая/ төгрөг
  - Зээлийн хугацаа: 12 /арван хоёр/ сар
  - Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа: 6 /зургаан/ сар
  - Зээлийн хүү: Төгрөгийн хүү жилийн 5.0 /таван/ хувь, эргэн төлөлт хийх хуваарьт өдөр зээлийн төлөлтийг хийгээгүй тохиолдолд түүнээс хойш тооцогдох зээлийн хүүгийн төлбөрт хүүгийн дэмжлэг олгогдохгүй бөгөөд зээлийн хүү 18.0 /арван найман/ хувьд шилжих,
- “Голомт Банк”-аас “Ноолуур бэлтгэлд зориулан олгох зээл” авч байгаатай холбоотойгоор “Говь” ХК болон “Таван Богд Холдингс” ХХК, “Таван Богд” ХХК, “Улаанбаатар Гурил” ХХК, “Улаанбаатар Принт” ХХК, “Таван Богд Интернэйшнл” ХХК, “Эйрлинк Монголиа” ХХК, “Таван Богд Моторс” ХХК, “Таван Богд Солюшнс” ХХК-иудын хамт тус банктай байгуулсан ЗББГС210207652/GNPLT тоот Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд дараах өөрчлөлтийг оруулахыг зөвшөөрсүгэй,
  - Эрхийн хэмжээг 9,500,000,000 /есөн тэрбум таван зуун сая/ төгрөг хүртэл буюу түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютаар бууруулах,
  - Эрх бууруулах хугацаа: Дээрх “Ноолуур бэлтгэлд зориулан олгох зээл” төлөгдөж дуусах хүртэл,
- “Ноолуур бэлтгэлд зориулан олгох зээл” авч байгаатай холбоотой үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар “Говь” ХК-ийн Хавсралт №1-д заасан хөрөнгийг барьцаалахыг зөвшөөрсүгэй.
- Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд нэмэлт өөрчлөлт орж байгаатай холбоотой үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар “Говь” ХК-ийн Хавсралт №2-д заасан хөрөнгийг үргэлжлүүлэн барьцаалахыг зөвшөөрсүгэй.
- Дээрх Зээлийн багц бүтээгдэхүүний нэмэлт гэрээ, барьцааны гэрээ, батлан даалтын гэрээ болон бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Дэд захирал /Э.Пүрэвхам/, “Говь” ХК-ийн Гүйцэтгэх захирал

2024 он 05 сар 07 өдөр

Дугаар 022

Улаанбаатар хот

/Б.Амарсайхан/ нарт, “Ноолуур бэлтгэлд зориулан олгох зээл”-ийн гэрээ, барьцааны гэрээ, бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Говь” ХК-ийн Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



*[Handwritten signatures]*

Б.АМАРСАЙХАН

Ц.БАТАРСАЙХАН

Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Н.МӨНХБАТ

Ц.ОРГИЛБОЛД

Э.ПҮРЭВЛХАМ

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР